

## ЗӨВЛӨМЖ

2020 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Зөвлөмж 1.** Авлигатай тэмцэх газраас авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хариуг хуульд заасан хугацаанд нь ирүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, бичиг хэргийн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

1. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс авлигын гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэст 2019 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 32 дугаартай, 12 дугаар сарын 16-ны өдрийн 34 дугаартай мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлсэн боловч хуульд заасан 1 сарын хугацаанд хариу ирүүлээгүй тул Авлигатай тэмцэх газраас 2019 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 06/2811 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийн хариу ирүүлэх талаар албан бичиг хүргүүлсэн байна.

Гэвч тус хэлтэс мөрдөгчийн мэдэгдэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй байна.

2. Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн гуравдугаар хэлтэст 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 35 дугаартай мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлсэн боловч тус хэлтсээс хуульд заасан 1 сарын хугацаанд хариу ирүүлээгүй тул Авлигатай тэмцэх газраас 2019 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 06/2811 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийн хариу ирүүлэх талаар дахин албан бичиг хүргүүлэхэд 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр “Мөрдөгчийн мэдэгдэлд заасан бүх арга хэмжээг хэрэгжүүлэн тодорхой арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна” гэсэн хариуг ирүүлсэн.

Хахууль авах авлигын гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээтэй газар дээр нь танилцахаар очиход 2019 оны 12 дугаар сарын 16-нд Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдэл аль хэлтэс, тасагт хуваарилагдсан нь тодорхойгүй, ямар ч ажил арга хэмжээ зохион байгуулаагүй байв.

Тус хэлтсийн 2019 оны ирсэн бичгийн бүртгэлийг шүүхэд Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийг хугацаагүй албан бичгээр бүртгэж, Төлөвлөлт зохион байгуулалт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, ахмад Б.Өнөрцэцэгт хуваарилсан боловч уг ажилтан мэдэгдлийн мөрөөр ямар ч ажил, арга хэмжээ зохион байгуулалгүйгээр жирэмсний амралтаа авч, дараагийн мэргэжилтэнд хүлээлгэн өгөлгүйгээр орхигдуулсан байна.

**Зөвлөмж 2.** Удирдах албан тушаалтнуудын зүгээс үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тавьж байгаа хяналтыг дээшлүүлэх.

Хэлтсүүдийн удирдах албан тушаалтнуудын зүгээс үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тавьж байгаа хяналтыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр авлигаас урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээ байхгүй байна.

Цагдаагийн албан хаагчдад Цагдаагийн албаны тухай хуульд заасан хориглох зүйл, Цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, сахилгын дүрэм, авлигын эсрэг хууль тогтоомжид заасан зөрчил дутагдлыг гаргахгүй байх талаар албан хаагч бүрээс тогтмол баталгаа гаргуулан, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох ажил хэвшээгүй, энэ ажил нэр төдий, хэлбэрийн шинжтэй байна.

Дээрх баталгаа, заавар, зөвлөмжүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьчилан сэргийлэх, иргэдэд хүнд сурталгүй, түргэн шуурхай үйлчлэх талаар тодорхой тусгагдаагүй, сахилга ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар огт дурдаагүй байх ба хариуцлага тооцох явдлыг үр дүнтэй болгох шаардлагатай байна.

***Зөвлөмж 3. Үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын энгэрийн камерыг хэрэглээг сайжруулах, хэлтсийн удирдлагын зүгээс албан хаагчдыг үүрэг гүйцэтгэхдээ тогтмол энгэрийн камераа ажиллуулах талаар бичгээр үүрэг чиглэл өгөх, үүрэг гүйцэтгэсэн албан хаагч энгэрийн камерын бичлэгийг холбогдох албан тушаалтанд хүлээлгэж өгөхдөө бүртгэлийн дэвтэр хөтлөн, гарын үсэг зуруулж байх, албан хаагчийн энгэрийн камерын хэрэглээ, бичлэгт ахлах ажилтан, удирдлагын зүгээс тогтмол хяналт тавих.***

Хэлтсийн Хэв журмыг хамгаалах тасгийн албан хаагчид үүрэг гүйцэтгэх хугацаандаа энгэрийн камерыг тогтмол ажиллуулж, албан үүргээ гүйцэтгэж дуусмагц техникийн ажилтанд энгэрийн камерын бичлэгийн хүлээлгэн өгч, нэгдсэн санд хуулбарлан үлдээдэг гэх боловч хэлтсийн удирдлагуудаас албан хаагч бүр үүрэг гүйцэтгэхдээ энгэрийн камер ажиллуулж байгаад хяналт тавин ажиллаж байгаа эсэх талаар албан хаагчидтай фокус ярилцлага хийхэд гэмт хэрэг, зөрчил давтан гарахад нөлөөлж болзошгүй дараах шалтгаан нөхцөлүүд тогтоогдож байна. Үүнд:

- 1) Иргэдтэй шууд харилцдаг эргүүлийн цагдаа нарт удирдлагаас энгэрийн камерыг тогтмол ажиллуулах талаар үүрэг болгосон гэх боловч албан хаагч шаардлагатай тохиолдолд буюу иргэд маргаан үүсгэсэн тохиолдолд ажиллуулдаг;
- 2) Үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн албан хаагч үүрэг гүйцэтгэж дуусмагц энгэрийн камерын бичлэгийг мэдээлэл технологи хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч, бүртгэлийн дэвтэр хөтөлж эхэлсэн боловч энэхүү ажил нь үр дүнтэй хэрэгжээгүй, албан хаагчид энгэрийн камерын бичлэгээ үүрэг гүйцэтгэж дуусмагц хүлээлгэж өгдөггүй, бүртгэлийн дэвтрийг тогтмол хөтөлж хэвшээгүй;
- 3) Энгэрийн камерыг мэдээлэл технологи хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч буйд хэлтсийн ахлах зохицуулагч хяналт тавьдаггүй;
- 4) Цагдаагийн албан хаагчид үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа энгэрийн камераа тогтмол ажиллуулж байгаа эсэхэд тавих удирдлагын хяналт сул;

***Зөвлөмж 4. Албан хаагчдын хууль бус зохисгүй үйлдэл, ёс зүйн харилцааны талаар гомдол, мэдээллийг хүлээн авах механизмыг илүү сайн бүрдүүлэх, ирүүлсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж хэвших, сахилга ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдад тухай бүр хариуцлага хүлээлгэх.***

Хэлтсийн албан хаагчдын хууль бус үйлдэл, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хэрхэн хүлээн авах талаар ямар ч зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, гомдол, мэдээллийн тоо, агуулга, эзэн холбогдогчийн талаарх нэгдсэн бүртгэл хөтлөөгүй байна.

Тус хэлтсээс сахилга, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдыг оролцуулж хэлэлцүүлсэн нийт албан хаагчдын хуралдааныг тогтмол зохион байгуулдаггүй, гомдол, мэдээлэл хүлээн авах механизмыг бодитой бүрдүүлээгүй, ирүүлсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг хэвшүүлээгүй, сахилга ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдад тухай бүр хариуцлага тооцоогүй, ихэнх зөрчилд сануулах хариуцлага оногдуулсан нь нөлөөллийн үр дүн муу, сахилга ёс зүйн зөрчил давтан гарах нөхцөлийг бий болгож байгааг анхаарч, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

***Зөвлөмж 5. Авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйг бүрдүүлэх чиглэлээр авлигын гэмт хэрэгт холбогдон шүүхээр шийтгэгдсэн албан хаагчдын талаар мэдээлэл өгөх сургалтыг практик хэлбэрээр зохион байгуулах.***

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан дотоод сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтэс 1, 3 дугаар хэлтсээс дотоод сургалтын төлөвлөгөөг батлуулан албан хаагчдад мэдвэл зохих хууль тогтоомжийг судлуулах, албан хаагчийг дадлагажуулах, бие бялдрыг хөгжүүлэх чиглэлийн сургалтуудыг жилийн туршид зохион байгуулсан боловч авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн сэдэвт сургалт тусгагдаагүй, мөн мөрдөгчийн мэдэгдэл хүлээн авснаас хойш авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр албан хаагчдад ямар нэгэн сургалтыг зохион байгуулаагүй байна.